


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар буюу **17-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 10 аймагт **1098** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1098 тохиолдлын 91% /1031/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 9% /66/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Орхон /4/, Өвөрхангай /5/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /1/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **323** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

## 17 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.04.19 – 2026.04.25)

2026 оны арван долоодугаар долоо хоногт 79 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 79.5 хувиар, 5 жилийн дунджаас 59.3 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.




### ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-17 дугаар долоо хоногт нийт 498** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



2026 оны арван долоодугаар долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн **33** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 135.7 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 123.0 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (17-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	5	6	11
2	Эмийн хордлого	6	16	22
<b>Нийт</b>		<b>11</b>	<b>22</b>	<b>33</b>

Нийт 33 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 22 (67%) нь эмийн хордлого, 11 (33%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 22 (67%) тохиолдол, санаатай хордлого 11 (33%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-